

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/39/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер У.Батсүрэн: Утас: 70378845 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Батмягмар Утас: 70373089 Цахим хаяг: batmyagmarg@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.05 № 13
танай _____-ны № _____-т

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
Б.МӨНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.16-т заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн 1,006,062.6 мянган төгрөгийн тогтмол зардлыг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 27,655,321.5 мянган төгрөгийг нэхэмжилснээс даатгалтай иргэдийн бичиг баримт болон эмчилгээний түүхийн зөрчлийн улмаас 1,604,943.0 мянган төгрөг хасуулсан нь, өмнөх оны хасагдуулгаас 76.7 хувиар буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн

4526050020

хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Нэгдсэн эмнэлгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 бүлэг 44 зорилтын хүрээнд 179 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,217,407,451.79	2,596,413,248.17
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	236,606,056.00	173,283,286.27
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	236,606,056.00	173,283,286.27
3121	Төгрөг	236,606,056.00	173,283,286.27
31211	Төрийн сангийн харилцах	236,606,056.00	173,283,286.27
33	АВЛАГА	2,394,157,362.90	847,831,334.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,498,000.05
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,391,300,260.90	837,752,158.00
335	Бусад авлага	2,857,102.00	8,581,176.00
3351	Байгууллагаас авах авлага	2,857,102.00	405,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	8,176,176.00
34	УРЬДЧИЛГАА	-	24,730,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	24,730,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,586,644,032.89	1,550,568,627.85
351	Түүхий эд материал	645,873,381.44	347,381,667.36
35130	Эм боох материал	645,873,381.44	347,381,667.36
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	83,133,847.08
354	Хангамжийн материал	940,770,651.45	1,120,053,113.41
35410	Бичиг хэргийн материал	49,587,990.00	33,700,380.00
35420	Аж ахуйн материал	32,769,860.27	24,678,237.07
35430	Сэлбэг хэрэгсэл	55,659,850.00	38,375,230.00
35440	Түлш, шатах тослох материал	4,306,180.00	1,224,770.00
35450	Барилгын засварын материал	8,654,685.00	-
35460	Хүнсний материал	-	11,133,815.15
35470	Бусад хангамжийн материал	789,792,086.18	1,010,940,681.19
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22,743,297,307.20	22,708,020,525.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,743,297,307.20	22,708,020,525.28
392	Биет хөрөнгө	17,145,110,932.20	17,108,646,858.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,110,661,735.41	12,110,661,735.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,597,955,008.49)	(3,087,347,073.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,227,141,173.80	1,225,506,173.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(368,577,724.93)	(529,016,156.45)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,179,446,660.63	13,241,939,804.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,043,049,916.68)	(6,622,034,251.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	332,893,406.34	510,775,462.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(187,863,980.18)	(147,936,938.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	948,475,865.77	965,869,730.41
39215	Хуримтлагдсан элэгдэл	(461,621,347.47)	(565,691,695.49)
39217	Ном	5,560,068.00	5,920,068.00
393	Биет бус хөрөнгө	5,598,186,375.00	5,599,373,666.47

39301	Програм хангамж	10,713,500.00	12,416,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,343,125.00)	(6,858,333.53)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,593,816,000.00	5,593,816,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>26,960,704,758.99</u>	<u>25,304,433,773.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,003,735,342.54</u>	<u>3,689,211,780.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,003,735,342.54	3,689,211,780.40
413	Өглөг	4,003,735,342.54	3,689,211,780.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	934,706,793.39	911,302,453.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,850,259,316.16	2,671,361,254.05
4136	Бусад өглөг	218,769,232.99	106,548,073.04
41361	Байгууллагад төлөх өглөг	209,274,232.99	88,530,931.04
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,495,000.00	18,017,142.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>22,956,969,416.45</u>	<u>21,615,221,993.05</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	22,956,969,416.45	21,615,221,993.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,626,717,083.16	7,626,717,083.16
51101	Өмч: - төрийн	7,626,717,083.16	7,626,717,083.16
512	Хуримтлагдсан үр дүн	7,251,212,278.10	5,909,464,854.70
51210	Өмнөх үеийн үр дүн	7,251,212,278.10	7,251,212,278.10
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,341,747,423.40)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,079,040,055.19	8,079,040,055.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>26,960,704,758.99</u>	<u>25,304,433,773.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,518,201,245.17	32,629,690,766.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,162,654,758.17	5,651,312,223.35
120	Нийтлэг татварын бус орлого	2,416,100,490.51	2,510,657,798.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,401,624,312.51	2,510,657,798.89
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	862,482,455.51	910,168,237.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	976,299,897.90	1,016,348,307.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	562,841,959.10	584,141,253.42
120005	Түрээсийн орлого	14,476,178.00	-
120009	Бусад орлого	-	-
122	Тусламжийн орлого	3,746,554,267.66	3,140,654,424.46
122001	Хандив тусламж /дотоод/	3,746,554,267.66	3,140,654,424.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,355,546,487.00	26,978,378,543.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	724,175,500.00	928,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	724,175,500.00	928,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,631,370,987.00	26,050,378,543.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,631,370,987.00	26,050,378,543.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	32,613,169,452.64	33,767,012,086.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,613,169,452.64	33,767,012,086.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,683,903,944.73	32,743,358,385.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,191,541,827.15	18,872,384,589.23
210101	Үндсэн цалин	9,469,136,313.23	10,413,727,865.15
210102	Нэмэгдэл	5,952,815,490.27	6,635,377,615.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	703,991,181.47	745,399,433.99
210104	Урамшуулал	1,065,598,842.18	1,077,879,674.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,230,253,643.89	2,467,548,952.14
210201	Тэтгэврийн даатгал	1,506,957,128.35	1,714,396,122.44
210202	Тэтгэмжийн даатгал	174,956,606.95	178,442,926.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	135,957,961.63	153,886,084.75
210204	Ажилгүйдлийн даатгал	82,144,916.28	83,653,798.83
210205	Эрүүл мэндийн даатгал	330,237,030.68	337,170,019.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	732,309,176.87	834,147,371.75
210301	Гэрэл, цахилгаан	236,570,278.62	296,805,213.62
210302	Түлш, халаалт	179,324,572.03	190,782,253.03
210303	Цэвэр, бохир ус	316,414,326.22	346,559,905.10
2104	Хангамж, бараа материалын зардал	392,112,485.93	372,137,034.24
210401	Бичиг хэрэг	23,869,290.00	21,303,910.00
210402	Тээвэр, шатахуун	156,704,003.00	155,295,910.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,066,384.79	34,231,847.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,590,500.00	17,975,990.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	180,882,308.14	143,329,377.19
2105	Нормативт зардал	7,046,338,085.68	6,851,011,636.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,109,316,910.68	6,298,293,386.78
210502	Хоол, хүнс	936,621,175.00	551,574,249.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	1,144,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	239,127,379.15	202,138,565.92
210604	Урсгал засвар	239,127,379.15	202,138,565.92
2107	Томилолт, зочны зардал	5,179,600.00	4,550,000.00
210702	Дотоод албан томилолт	5,179,600.00	4,550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,842,356.13	106,410,476.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,086,681.00	38,639,380.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	579,800.00	8,686,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,708,222.21	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	599,558.00	938,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	550,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,428,000.00	21,800,000.00
210807	Газрын төлбөр	10,681,384.00	10,681,384.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,775,210.92	3,637,712.73
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,433,500.00	21,719,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,752,199,389.93	3,033,029,758.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,377,624.71	9,128,196.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,485,000.00	13,988,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,720,336,765.22	3,009,913,262.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	929,265,507.91	1,023,653,700.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	921,937,318.00	1,022,932,961.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	593,115,228.00	486,271,661.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	313,171,000.00	505,120,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,651,090.00	31,540,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,328,189.91	720,739.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(94,968,207.47)	(1,137,321,319.65)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	917,124.71	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	917,124.71	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,562,500.00	204,426,103.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,562,500.00	204,426,103.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,645,375.29)	(204,426,103.75)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(100,613,582.76)	(1,341,747,423.40)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>27,252,067,490.30</u>	<u>30,449,081,404.64</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,847,045,445.20	1,917,154,758.74
120	Нийтлэг татварын бус орлого	1,847,045,445.20	1,917,154,758.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,832,276,467.20	1,917,154,758.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	855,707,244.59	898,354,349.26
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	976,569,222.61	1,018,800,409.48
120005	Түрээсийн орлого	14,768,978.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,405,022,045.10	28,531,926,645.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	724,175,500.00	928,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	724,175,500.00	928,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,680,846,545.10	27,603,926,645.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,680,846,545.10	27,603,926,645.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>26,888,395,783.60</u>	<u>30,473,996,014.37</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,888,395,783.60	30,473,996,014.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,964,680,275.69	29,452,642,255.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,029,111,895.91	19,131,408,549.84
210101	Үндсэн цалин	9,046,712,139.09	10,790,113,353.04
210102	Нэмэгдэл	5,900,932,364.50	6,586,586,266.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	703,105,078.69	744,151,806.96
210104	Урамшуулал	1,378,362,313.63	1,010,557,123.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,301,104,947.27	2,233,427,331.66
210201	Тэтгэврийн даатгал	1,546,602,534.59	1,572,714,886.78
210202	Тэтгэмжийн даатгал	184,809,255.40	156,502,276.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	141,410,129.10	135,061,873.72
210204	Ажилгүйдлийн даатгал	80,073,251.36	73,362,232.98
210205	Эрүүл мэндийн даатгал	348,209,776.82	295,786,061.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	827,672,458.02	834,147,371.75
210301	Гэрэл, цахилгаан	254,227,578.62	296,805,213.62
210302	Түлш, халаалт	229,050,595.06	190,782,253.03
210303	Цэвэр, бохир ус	344,394,284.34	346,559,905.10
2104	Хангамж, бараа материалын зардал	279,653,335.80	281,024,270.00
210401	Бичиг хэрэг	13,693,600.00	35,618,300.00
210402	Тээвэр, шатахуун	158,998,700.00	129,985,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,923,185.80	30,782,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,722,500.00	25,000,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,315,350.00	59,638,970.00
2105	Нормативт зардал	5,123,466,520.48	6,414,846,049.39
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,210,095,925.68	5,692,529,215.85
210502	Хоол, хүнс	912,370,594.80	710,316,833.54
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	12,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	267,278,073.00	434,803,593.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,022,506.00	94,199,540.00
210602	Тавилга	1,320,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,503,840.00	560,000.00
210604	Урсгал засвар	243,431,727.00	335,044,053.00
2107	Томилолт, зочны зардал	5,179,600.00	4,550,000.00
210702	Дотоод албан томилолт	5,179,600.00	4,550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,865,123.00	89,947,864.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,502,181.00	32,584,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	579,800.00	8,849,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,708,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	599,558.00	938,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	550,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,428,000.00	20,000,000.00
210807	Газрын төлбөр	10,681,384.00	10,681,384.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,816,000.00	16,585,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,348,322.21	28,487,226.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,102,322.21	9,943,196.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,246,000.00	18,544,030.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	923,715,507.91	1,021,353,758.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	916,387,318.00	1,020,633,019.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	593,115,228.00	486,021,719.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	313,171,000.00	505,120,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,101,090.00	29,490,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,328,189.91	720,739.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>363,671,706.70</u>	<u>(24,914,609.73)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	145,333,810.00	38,408,160.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,333,810.00	38,408,160.00
2200	Дотоод эх үүсвэрээр	145,333,810.00	38,408,160.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	145,333,810.00	38,408,160.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(145,333,810.00)</u>	<u>(38,408,160.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	218,337,896.70	(63,322,769.73)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,268,159.30	236,606,056.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	236,606,056.00	173,283,286.27

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,351,807,869.96	23,057,565,008.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	17,990.90	17,990.90
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,351,825,860.86	23,057,582,999.21
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(100,613,582.76)	(100,613,582.76)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,251,212,278.10	22,956,969,416.45
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,251,212,278.10	22,956,969,416.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	7,251,212,278.10	22,956,969,416.45
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,341,747,423.40)	(1,341,747,423.40)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,626,717,083.16	8,079,040,055.19	5,909,464,854.70	21,615,221,993.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	236,606,056.00	(236,606,056.00)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,951,580,700.00	29,511,191,194.16	440,389,505.84	98.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	100.0
НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,512,391,000.00	27,603,926,645.90	(91,535,645.90)	100.3
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,512,391,000.00	27,603,926,645.90	(91,535,645.90)	100.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,439,189,700.00	1,907,264,548.26	531,925,151.74	78.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,030,220,200.00	898,354,349.26	131,865,850.74	87.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,172,363,500.00	1,008,910,199.00	163,453,301.00	86.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	236,606,000.00	-	236,606,000.00	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,951,580,700.00	29,574,513,963.89	377,066,736.11	98.7
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	29,951,580,700.00	29,574,513,963.89	377,066,736.11	98.7
Бараа, үйлчилгээний зардал	28,754,160,200.00	28,553,880,944.89	200,279,255.11	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,164,978,800.00	19,131,408,549.84	33,570,250.16	99.8
Үндсэн цалин	10,685,779,800.00	10,790,113,353.04	(104,333,553.04)	101.0
Нэмэгдэл	6,864,584,400.00	6,586,586,266.47	277,998,133.53	96.0
Унаа, болон бусад нөхөн олговор	768,992,800.00	744,151,806.96	24,840,993.04	96.8
Урамшуулал	845,621,800.00	1,010,557,123.37	(164,935,323.37)	119.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,233,427,400.00	2,233,427,331.66	68.34	100.0
Тэтгэврийн даатгал	1,580,229,000.00	1,572,714,886.78	7,514,113.22	99.5
Тэтгэмжийн даатгал	188,299,600.00	156,502,276.73	31,797,323.27	83.1
ҮОМШӨ ний даатгал	94,149,800.00	135,061,873.72	(40,912,073.72)	143.5
Ажилгүйдлийн даатгал	94,149,800.00	73,362,232.98	20,787,567.02	77.9
Эрүүл мэндийн даатгал	276,599,200.00	295,786,061.45	(19,186,861.45)	106.9
Хангамж, бараа материалын зардал	283,848,900.00	282,329,270.00	1,519,630.00	99.5
Бичиг хэрэг	37,449,300.00	35,978,300.00	1,471,000.00	96.1
Тээвэр (шатахуун)	130,000,000.00	129,985,000.00	15,000.00	100.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	30,782,000.00	30,782,000.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	60,617,600.00	60,583,970.00	33,630.00	99.9
Нормативт зардал	6,560,723,500.00	6,414,846,049.39	145,877,450.61	97.8
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	5,858,518,200.00	5,692,529,215.85	165,988,984.15	97.2
Хоол, хүнс	690,205,300.00	710,316,833.54	(20,111,533.54)	102.9
Нормын хувцас зөөлөн эдлэл	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
Эд хогшил худалдан авах	373,890,100.00	373,884,654.00	5,446.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	130,452,700.00	130,452,700.00	-	100.0
Тавилга	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	560,000.00	560,000.00	-	100.0
Урсгал засвар	237,877,400.00	237,871,954.00	5,446.00	100.0
Томилолт, зочны зардал	6,000,000.00	4,550,000.00	1,450,000.00	75.8
Дотоод албан томилолт	6,000,000.00	4,550,000.00	1,450,000.00	75.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	101,596,500.00	89,947,864.00	11,648,636.00	88.5

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,296,600.00	32,584,780.00	5,711,820.00	85.1
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	8,930,100.00	8,849,700.00	80,400.00	99.1
Даатгалын үйлчилгээ	4,844,000.00	-	4,844,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	938,300.00	938,300.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	627,000.00	308,000.00	319,000.00	49.1
Мэдээллийн технологийн зардал	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
Газрын төлбөр	10,696,000.00	10,681,384.00	14,616.00	99.9
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	648,000.00	-	648,000.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	16,616,500.00	16,585,700.00	30,800.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	29,695,000.00	23,487,226.00	6,207,774.00	79.1
Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	4,943,196.00	1,056,804.00	82.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,695,000.00	18,544,030.00	5,150,970.00	78.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,197,420,500.00	1,020,633,019.00	176,787,481.00	85.2
Бусад урсгал шилжүүлэг	1,197,420,500.00	1,020,633,019.00	176,787,481.00	85.2
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	555,262,800.00	486,021,719.00	69,241,081.00	87.5
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	600,012,000.00	505,120,900.00	94,891,100.00	84.2
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	42,145,700.00	29,490,400.00	12,655,300.00	70.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	236,606,056.00	(236,606,056.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	173,283,286.27	(173,283,286.27)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	562.00	578.00	(16.00)	102.8
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	454.00	467.00	(13.00)	102.9
Үйлчлэх ажилтан	107.00	110.00	(3.00)	102.8
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	562.00	578.00	(16.00)	102.8
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/	455.00	468.00	(13.00)	102.9
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	107.00	110.00	(3.00)	102.8

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160,563.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2,368.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 8,373.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажиллах 149,822.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүллээ.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 2 зөрчилд нийт 2,368.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант онд эд хариуцагч нарт олгох хариуцлагын нэмэгдлийг баримтлаагүйгээс ахлах нягтлан бодогч Б.Энхзаяад 291.9 мянган төгрөг, материалын нярав Ю.Баянзул 88.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгож, нийт 380.3 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.5, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/69 дугаар тушаалын 1.9-д “*Эрүүл мэндийн салбар хариуцлагатай албан тушаал болох Тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт хариуцлагын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-аас доошгүй хувиар, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээтэй эд хариуцагч нарт үндсэн цалингийн 8-аас доошгүй хувийн нэмэгдэл хөлс олгох*” гэж тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд хавсран гүйцэтгүүлсэн ажлын нэмэгдэл хөлсийг хашиж байгаа албан тушаалын үндсэн цалингаас тооцсоноос захирал Б.Мөнхбатад 64.8 мянган төгрөг, эмчилгээ эрхэлсэн орлогч Х.Буяндэлгэрт 294.6 мянган төгрөг, Эдийн засаг төлөвлөлтийн албаны дарга Т.Лхагва-Очирт 1,289.4 мянган төгрөг, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний албаны дарга Э.Сарнайд 338.7 мянган төгрөг нийт 1,987.7 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2-т тус тус заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Байгууллагын тасгийн эрхлэгч Г.Бадамлянхуа, эрчимт эмчилгээний эмч О.Болор-Эрдэнэ, Ж.Батчимэг нарт батлагдаагүй орон тоонд хавсран ажиллуулж нийт 8,373.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.3, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

3.3 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийн үлдэгдлийг шалгахад барагдуулах боломжтой 10,079.2 мянган төгрөгийн авлага, 139,742.9 мянган төгрөгийн өглөг үүсгэж, нийт 149,822.1 мянган төгрөгийн авлага, өр төлбөр бүртгэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөрийг 50 хувиар бууруулж ажиллах.

Дээрх зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан	Тоо	Дүн
Эд хариуцагч нарт олгох хариуцлагын нэмэгдлийг баримтлаагүйгээс 2 албан хаагчид илүү олгосон	1	380.3	1	380.3	-	-	-	-	-	-	-	-
Хавсран гүйцэтгүүлсэн ажлын нэмэгдэл хөлсийг хашиж байгаа албан тушаалын үндсэн цалингаас тооцсоноос 4 албан хаагчид нэмэгдэл хөлс илүү олгосон	1	1,987.7	1	1,987.7	-	-	-	-	-	-	-	-
Батлагдаагүй орон тоонд хавсран ажиллуулж нэмэгдэл хөлс олгосон	1	8,373.0	-	-	1	8,373.0	-	-	-	-	-	-
Тайлант онд авлага, өр төлбөр үүсгэсэн байна.	1	149,822.1	-	-	-	-	1	149,822.1	-	-	-	-
Дүн	4	160,563.2	2	2,368.0	1	8,373.0	1	149,822.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 17 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 1 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.	1	2,419,231.5	-	-	1	2,419,231.5	-	-		
Дүн	1	2,419,231.5	-	-	1	2,419,231.5	-	-		
Нийт дүн	5	2,579,794.7	2	2,368.0	2	2,427,604.6	1	149,822.1		

